

## **Тэднийг ойлгодог бол ок. Ойлгохгүй байсан ч ок**

### ***“СИТИ” их сургуулийн Сэтгүүл зүйн 3-р курсийн оюутан Ч.Энхчулуун***

Энэ хорвоод маш олон сонирхолтой хүмүүс бий. Сайн, муу аль нь ч бай бүх хүн сонирхолтой.

Комедиан Б.Идэр-Одын хошигнол, ёгтлолыг бүрэн дүүрэн ойлгож чадахгүй атлаа, физик зэрэг шинжлэх ухааны онол, хуулийг маш сайн ойлгох, ойлгоод зогсохгүй нарийн учрыг нь тайлж чадах маш онцгой хүмүүс байдаг. Тэднийг аутистик гэж нэрлэдэг. Тэдэн дунд Алберт Эйнштэйн, Чарлз Дарвин, Исаак Ньютон, Илон Маск бий. Эдгээр хүмүүс нь аутизм гэх эмгэгийнхээ нэг шинж болох сонирхсон зүйлдээ гүн автдаг туйлшрамтгай байдлынхаа ачаар түүхэнд нэрээ үлдээсэн байхыг үгүйсгэх аргагүй.

Эдгээр хүмүүстэй ижил аутизмын хүрээний эмгэгтэй Т.Энэрэл гэх хайр татам охин тантай нэгэн цаг үед нэг улсад амьдарч байна. Охин жирийн хүүхдүүдээс бага зэрэг “ӨӨР”. Тэр аутизмын хүрээний эмгэгтэй ч өрөвдмөөр нэгэн биш гэдгийг онцлон дурдья. Учир нь аутизм бол өвчин биш бусадтай харилцах, нийгмийн харилцаанд орох, мэдээллийг хүлээж авч ойлгох чадварт нөлөөлдөг эмгэг. Оюуны чадамж нь энгийн хүнтэй ижил, нийгмийн харилцаанд орох чадвар нь л сул гэсэн үг.

Аутизмтай хүүхэд бүрийн онцлог харилцан адилгүй. Т.Энэрэл хэт хөдөлгөөнтэй төрлийн онцлогтой. Хаашаа ч хамаагүй гүйчихдэг. Тийм ч сайн ярьдаггүй болохоор бусадтай ойлголцож чадахгүй байгаадаа стрессдэж жирийн бидний нүдэнд дураараа гэж харагдахуйц үйлдэл хийх нь их. Ер нь ийм эмгэгтэй хүмүүс сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ жаахан эв хавгүй. Та хэн нэгэнд талархалаа илэрхийлэхдээ тэвэрдэг бол аутизмтай хүн ийм үед тухайн хүнээ түлхээд авч мэднэ. Найзтай болмоор байвч яаж хамтдаа тоглох учраа олдоггүй. Оюун ухаан цоо эрүүл ч бусадтай яаж харилцах чадвар султай гэсэн үг.

Т.Энэрэлийн ээж Г.Ууганчимэгтэй ярилцах гэж очихдоо бусад хүмүүс хүүхдийг нь ойлгодог болоосой гэж хүсдэг байх даа гэж дотроо тааварлаж байв.

Гэхдээ түүнээс нэг зүйлийг шударгаар асуух ёстой байлаа. Бага зэрэг хэцүү ч хорвоо тэдэнд тавих тийм л асуулт.

- Хүмүүс яагаад таны хүүхдийг ойлгох ёстой гэж? Хэн ч хэнийг ч ойлгохын тулд төрөөгүй шүү дээ? гэх асуулт шударга бөгөөд бодит байдалд нийцнэ.

Гэвч энэ нь түүнд тийм ч хүнд асуулт байгаагүй юм. “Нийгэм тэднийг ойлгох албагүй ээ. Ер нь Монголд ийм зүйлд бэлэн хүн маш цөөхөн. Тэгэхээр миний охины онцлогийг таньж чаддаг, мэддэг хүн олон болоосой гэж боддог. Нөгөө талаар бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нь хүнлэг чанар шүү дээ. Хүүхдүүд, насанд хүрэгчид ялгаагүй хүнлэг энэрэнгүй байхад л бидэнд хангалттай” гэсэн юм. Товчхондоо аутизмтай хүнийг ойлгодог бол ОК. Ойлгохгүй байсан ч ОК. Танаас эсвэл таны хүүхдээс арай өөр хэн нэгэн таарвал дүгнэлт хийх гэж яаралтгүй бага зэрэг хүлээцтэй хандаж, байгаагаар нь хүлээж авахад л хангалттай аж. Байгаагаас нь хэтийдсэн сайн сайхнаар ч бодох хэрэггүй. Цаашлаад багахан боломж олгоод, тайвнаар харилцаж, танилцаж, дотносвол бүр сайн. Гэхдээ тэр тийм ч чухал биш байж болно. Гол нь ялгаатай байдлыг нь хүлээн зөвшөөрөөсэй.

Дэлхийн нийт хүн амын 1% нь аутизмын хүрээний эмгэгтэй. Монгол Улсад яг гаргасан албан ёсны нарийн тоо байхгүй. Дунджаар сургууль, цэцэрлэг тус бүрт ийм эмгэгтэй 1-5 хүүхэд бий гэж Монголын Аутизмын Холбоо үздэг. Аутизмын шалтгааныг шинжлэх ухаан хараахан тогтоогоогүй. Ийм хүүхдүүд үсэг, тоо, байгальд маш их татагддаг. Яагаад гэвэл гэнэтийн өөрчлөлт, хувирамтгай зүйл тэднийг тухгүй болгодог. Ер нь тэнгэрийн өнгө хувирахгүй шүү дээ. Тэд ой тогтоолт маш сайтай. Явсан газар, харсан зүйлээ маш сайн тогтоодог. Мэдрэмж нь маш өндөр тул тавгүйтүүлэх олон зүйлтэй учирдаг.

Т.Энэрэлийн ээж аутизмтай хүнийг таньж чаддаг, мэддэг хүн олон болоосой гэж хэлсэн нь санаандгүй зүйл биш байлаа. Охин дархлаа их султай байж. Бүр нялхаасаа харьяа өрхийн, дүүргийн, хүүхдийн, мэдрэлийн гээд бүх чиглэлийн эмч нарын хяналт дор эмнэлэгт голдуу цагийг өнгөрөөжээ. Гэвч тэдний хэн нь ч охиныг аутизмын хүрээний эмгэгтэй гэж анзаараагүй 3 нас хүртэл нь тусламж, үйлчилгээ үзүүлсэн байгаа юм. Мөн цэцэрлэгт ороход нь багш нар хүүхэдтэй нь ажиллах арга, учраа олохгүй зугтах, дөлөх хандлагатай байсан нь хүндрэлтэй

байж. Энэ талаар аутизмтай хүүхэдтэй аав П.Анар “Сонсголын ямар ч бэрхшээлгүй хэр нь нэрээр нь дуудахад харахгүй байх нь ийм эмгэгийн шинж тэмдгүүдийн нэг. Монгол эмч нар нэгэн хүүхдийн аутизмын шинжийг танилгүй сонсголгүй гэж оношлоод чихэнд нь хагалгаа хийх гэж байсан тохиолдол ч гарсан” гэж ярьж байлаа.

Мэргэжлийн хүмүүс энэ эмгэгийг оношилж чадахгүй байх нь хүүхэд, эцэг, эхэд ирэх дарамтыг нэмэгдүүлэх тохиолдол ч бий. Хүүе танай хүүхэд ийм том байж ярьж чаддаггүй юм уу? Яагаад байнга ээж, аавтайгаа зууралдаад байдаг байнаа? Яасан дураараа юм бэ? Хүүхдээ сайн хүмүүжүүлмээр юм байна даа зэргээр хамаатан садан, найз нөхдөөс шүүмжлэл ирдэг нь өдөр бүр, цаг тутамд хичээж байгаа гэр бүлд хүндээр тусах нь цөөнгүй. Хичээл зүтгэл нь тэдний хувьд маш үнэ цэнтэй. Тэд хүүхдээ нэг ч болов үг хэлүүлэх гэж, аль болох биеийг нь даалгах гэж маш их хичээж буй. Жирийн хүүхдийн хувьд байдаг л нэг чадварыг аутизмтай хүүхэд сурахад тэр гэр бүлд олимпын медаль авсантай дүйх хөөр баяр болно. Сард, улиралд хэд л бол хэдэн удаа ийм баяр хөөр тохионо гэхээр нэг талаар жирийн гэр бүлүүдээс илүү азтай мэт.

Дэлхий дээр анх 1943 онд энэ эмгэгийг оношилсон бол манай улс 2011 оноос оношилж эхэлсэн юм. Тэгэхээр бид энэ чиглэлийн ойлголттой эрүүл мэнд, боловсролын салбарын мэргэжилтэн тун цөөтэй. Багшийн мэргэжил олгох дээд боловсролын агуулгад 2013 оноос л энэ талаар хичээл орж эхэлсэн. Гэхдээ бодит байдал дээр жирийн хүүхдээс илүү их ажиллах, заах арга шаардлагатай хүүхэд ангид нь явж буй багш нарт цалингийн нэмэгдэл тун багыг олгодог. /Үндсэн цалингийн 10% /

Нэгэнт ийм төрлийн хүмүүстэй ажиллах хүн цөөн тул эцэг, эхчүүд өөрсдөө Монголын Аутизмын Холбоог байгуулж багш нарт, эмч нарт, олон нийтэд, төр засагт энэ эмгэгийн онцлогийг таниулах, энэ төрлийн эмгэгтэй хүүхдүүдтэй хэрхэн ажиллахыг, тэд жирийн л хүмүүс гэдгийг ойлгуулах гэж идэвхтэй ажиллаж иржээ. Энэ холбоонд аутизмтай хүүхдүүдийн эцэг эхчүүд сайн дураар ажилладаг. Тус холбооны гүйцэтгэх захирал Ш.Байгалмаа ярихдаа “Бид 10, 20 жил ажиллаж байгаа эмч, багш нарт аутизмтай хүүхэдтэй хэрхэн ажиллахыг заадаг. Олон нийтэд зөв ойлголт өгөх ажлуудыг тогтмол хийдэг. Аутизмын талаар нэг ч гэсэн хүнийг зөв ойлголттой болгохын тулд аутизмтай хүүхдүүдийн

аав, ээжүүд уйгагүй хичээдэг” гэлээ. Хүүхэд нь аутизмтай гэж оношлогдсон хүмүүсийн хувьд ч энэ байгууллага маш том түшиг тулгуур нь болдог.

Ээжийнх нь хэлснээр Т.Энэрэл охиныг ялгаатай байдлаас нь болж үеийнхэн нь гадуурхах, зарим эцэг эхчүүд нүд үзүүрлэх тохиолдол хэд хэд гарсан байна. Ийм зүйл олон гэр бүлд тохиолддог байж мэднэ. Жиргээнд “Horloo” гэх хэрэглэгч аутизмтай хүү нь 21 нас хүрсэн, эргээд харахад гадуурхал, шантрал гээд олон зүйлийг туулсан тухайгаа бичсэнтэй таарсан юм. Ер нь Т.Энэрэл тэгж болохгүй, ингэж болохгүй. Ингэвэл бусад хүн ойлгохгүй гэдэг стандартад баригдаж амьдардаг. Заримдаа аутизмтай гэдгээрээ хэлмэгдэх үетэй ч таарна. Хүүхэд шүү дээ. Хүүхдүүд заримдаа сахилгагүй, заримдаа зөрүүд. Асуудал түүнийг “Өө энэ чинь юутай ч билээ нэг өвчтэй. Тийм болохоороо л ингээд байна” гэж хардаг бий.

Үнэндээ аутизмтай хүн нь жирийн нэгэн бөгөөд өөрийн байгаа байдлыг нь хүмүүс хэрхэн хүлээж авч байгаад шаналж байдаг. Ийм эмгэгтэй хүмүүсийн толгой, сэтгэл дотор яг юу болдог тухай бичиж чамгүй амжилт гаргасан Хигашида Наоки гэх аутизмтай Япон хүү бий. Тэрээр “Би яагаад үсэрдэг вэ?” нэртэй номондоо “...Жирийн хүн бол сэтгэл нь тавгүй болоход хүнээс асуух зэргээр асуудлаа шийдэх гэдэг. Бид бол тавгүй байдлаа хүнд мэдрүүлж чаддаггүй. Паникт ороход маань ихэнх хүн буруу таамаглал дэвшүүлдэг, уйлахаа боль зэргийн үг л хэлдэг...” гэж бичжээ. Мөн тэд алдаандаа маш их шаналдаг ч залруулж чаддаггүйгээ, өөрөөс нь болоод бусад хүмүүс гунигт автахад санаа нь ямар ихээр зовдог талаар ч номонд гарна. Түүнчлэн аутизмтай хүний хувьд жирийн байх гэдэг нь аутизмтай байхыг хэлдэг тухай бичжээ.

Тэгэхээр бидэнд ч бусдаас ялгаатай зүйл цөөнгүй. Түүнийг маань байгаагаар нь хүлээж авч буй хэнд ч талархаж, хайрладаг. Та түүнээс өөр байсан ч тэр та 2 тэгш эрхтэй. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "All human beings are born free and equal in dignity and rights" гэж бичээд хүн төрөлхтөнд тунхагласан. Таны дэргэд аутизмтай хүн байгаа бол, таны хүүхдийн ангид ийм хүүхэд бий бол тэд төрхөд нь яг та бидэнд заяасан шиг суурь эрхээ л эдэлж бидэнтэй хамт оршиж байгаа. Тийм болохоор тэдний оршихуйд хэт анхаарлаа хандуулж, байгаа байдалд нь сөрөг хариу үйлдэл үзүүлэхгүй байхад л хангалттай. Тэднийг бодит байдлаас илүү гоё, сайхнаар ч бодох хэрэггүй. Зүгээр л яг байгаагаар нь хүлээж

авдаг болчихвол сайхан. Мэдээж тэдэнтэй нөхөрлөх, хамтран ажиллах нь тэр хүн болоод та хоёрын хувийн сонголт, шийдвэр байх болно.